



2025 он 05 сар 14 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

**Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих
эргэлтийн хөрөнгийн ногоон зээлийн гэрээ байгуулах тухай**

“Говь” ХК нь “ХААН” банкттай зээлийн гэрээ байгуулах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18, 89 дүгээр зүйлийн 89.1, 92 дугаар зүйлийн 92.1 дэх заалтыг тус тус удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. “Говь” ХК нь дараах нөхцөлийн дагуу “ХААН” банкттай “Ноос, ноолуур, арьс ширний боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих эргэлтийн хөрөнгийн ногоон зээл” авах гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
 - 1.1. Зээлийн хэмжээ: 6,000,000,000 /зургаан тэрбум/ төгрөг;
 - 1.2. Зээлийн хугацаа: 24 /хорин дөрвөн/ сар;
 - 1.3. Зээлийн хүү: Төгрөгийн зээлийн хүү жилийн 16.0 /арван зургаан/ хувь, Засгийн газраас хариуцан төлөх зээлийн хүүгийн хөнгөлөлт нь жилийн хувьсах 10.0 /арван/ хувь.
2. Дээрх хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдох тул Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэн баталсугай.
3. Зээлийн гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Санхүү удирдлага хариуцсан захирлын үүрэг гүйцэтгэгч /Б.Оргил/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

А.ЖАРГАЛМАА

Д.ХҮРЭЛБААТАР